

СОЁМБО МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

НАЙМАН ГА ГАЗАРТ МОД ТАРЬЖ, НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙВ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан БХЯ болон түүний харьяа байгууллагууд, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангиудын алба хаагчид Баянзүрх хайрханы энгэрт 20 мянган гаруй шинэс мод тарилаа. Нийслэлийн ЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Чинагийн Галсан” сантай хамтран хэрэгжүүлсэн нийгмийн хариуцлагын хүрээнд дэх энэхүү сайн үйлсийн аянд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, Ж.Чинбүрэн, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар нарын БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал болон Нийслэлийн ЗДТГ-ын удирдлагууд, МУСГЗ, зохиолч Ч.Галсан нарын хүмүүс оролцлоо.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр нээлтийн үеэр Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн жил бүр мод тарьж хэвшсэн, тарьсан модоо ч эргэж тойрч усалдаг хариуцлагатай хэмээн тодотгоод Зэвсэгт хүчний бүх нэгтгэл, ангиудад “Экологийн анги” хэмээх шинэ төсөл хэрэгжүүлэх болсон талаараа дурдлаа. Өөрөөр хэлбэл, ажлын байрныхаа орчин тойронд агаарын бохирдлыг бууруулж, эх орон, байгаль дэлхийгээ хайрладаг уламжлалт монгол зан заншлаа дээдэлж, хүн бүр байгалиа нөхөн сэргээх, хамгаалахад гар бие оролцох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор технологийн дагуу зүлэгжилт, технологийн дагуу тарьсан мододтой экологийн хотхон болгох зорилго тавьжээ.

Мөн энэ үеэр МУСГЗ, зохиолч Ч.Галсан “Цэргийн алба хаагчидтай 12 жилийн өмнө өнөөдрийнх шиг олон мянган мод тарьж байлаа. Одоо тэр тарьсан мод маш үзэсгэлэнтэй ой болсон байна” хэмээгээд цэргийнхэн байгаль орчноо арчилж, моджуулж, ойжуулахдаа бусад салбарыг тэргүүлэгч хамт олон гэж тодотгосон юм. Тэрээр өөртөө 1 сая мод тарина гэж амлалт өгч байсан, амлалтаа бараг биелүүлэх дөхсөн байна. Монгол ухаанаар 100 модыг нэг ой гэж ойлгодог. Энэ ойлголтоор миний тарих сая мод арван мянган ой болох юм. Тэгэхээр би өөрийнхөө хөрөнгөөр эх орондоо арван мянган ой буюу нэг сая мод тарьж байна гэлээ.

Үүний дараа “Чинагийн Галсан” сангийн тэргүүн Г.Галтайхүү шинэс мод тарих дарааллыг танилцуулж, БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын алба



хаагчдад тарааж өгөөд уулархаг бүсэд мод тарихад ургах магадлал их өндөр. Учир нь чийгтэй бас нарны тусгал сайтай гэдгийг онцолж байсан юм.

БХЯ болон түүний харьяа байгууллагууд, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Улаанбаатар

цэргийн хүрээний нэгтгэл, ангиудын алба хаагчид ногдсон талбайдаа зааврын дагуу мод тарьж байгаа юм. Ташрамд дурдахад, шинэс нь жавартай, сэрүүн орчинд маш тэсвэртэй бөгөөд 150-200 жил насалж, 15-45 метр өндөр ургадаг, сүрлэг оройтой мод юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	🌧️ 3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	🌧️ 23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 25	🌧️ 11

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.845.00	2.856.00
EUR 🇪🇺	3.400.00	3.505.00
CNY 🇨🇳	441.00	444.90
RUB 🇷🇺	37.40	40.10
JPY 🇯🇵	25.59	26.46
KRW 🇰🇷	2.40	2.62

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 05
2021.05.17.
/ДАВАА ГАРАГ/

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН
МОГОЙ САРЫН ЗУРГААН
ЦАГААН ХӨХӨГЧИН
ҮХЭР ӨДӨР**

Үс засуулбал:

Эд, мал арвижна.
Наран ургах, шингээ:
05.11-20.26

Барилдлага:
Үхэх

Шүтэн барилдлага:
Сансар

Суудал:
Шороо.

Арвын тооллын 5 сарын 17, Сумъяа гараг. Билгийн тооллын давхарласан 5, Найралт эх одтой, хөхөгчин үхэр өдөр. Өдрийн наран 5 цаг 11 минутад мандан, 20 цаг 26 минутад жаргана. Тухайн өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адуус муулах, мал арилжаа, буг дарах, газрын ам бооход сайн. Байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.

ЦЭРГИЙНХНИЙ "ОЛИМП" ЭХЭЛЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд эхэллээ. Тэмцээний нээлтийн арга хэмжээнд ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар, Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар, БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа С.Ганбямба, БХЯ-ны ГХАГ-ын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ нар оролцлоо. Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн

хүрээнд зохион байгуулж байгаа энэхүү тэмцээн нь 2007 оноос хойш уламжлал болон явагдаж ирсэн бөгөөд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, цэргийн алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг нэмэгдүүлэх, цэргийн сургалт бэлтгэлийг дээшлүүлдэг онцлогтой. Энэ удаагийн тэмцээнд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын баг тамирчид оролцож чадаагүй ч Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалуудын хэмжээнд зохион байгуулж байна. Цэргийн алба хаагчдын

мэргэжлийн ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшнийг сорих уг тэмцээн оролцогчдын тоог салаанаас рот хүртэлх бүрэлдэхүүнтэй



болгон нэмэгдүүлж, тэмцээний журамд эзлэгдсэн объектыг чөлөөлөх, буудлагын шинэ төхөөрөмжүүд ашиглах зэрэг өөрчлөлтийг оруулсан юм. Үүний дараа зарим баг,

тамирчдад цэрэгжлийн спортын шагнал гардуулж, Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээнийг зохион байгуулж явуулахад идэвх санаачилгатай ажилладаг зарим бүрэлдэхүүнийг шагнаж, урамшууллаа.

Тэмцээнд ЗХЖШ, ХЗЦК, АЦК, ТХЦК-ын харьяа нэгтгэл, ангиудын рот, байнгын бүрэлдэхүүний болон хугацаат цэргийн алба хаагчдын салаа, эмэгтэй цэргийн алба

хаагчдын тасаг оролцож байна. Тус тэмцээнд оролцогч баг тамирчид нь цар тахлын халдвараас сэргийлэх хүрээнд вакцины хоёрдугаар тундаа бүрэн хамрагдсан алба хаагчид юм.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

48.642

ЭДГЭРСЭН

40.900

НАС БАРСАН

207/12

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2299 (30)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

238

ЭДГЭРСЭН

2031

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 161,513,458

Эдгэрсэн

Нийт: 135,851,889

Нас барсан

Нийт: 3,352,109

ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ
10,308	2,441,556
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/ СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ
4,764	2,827,220
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ
1,109	404,508
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ
754	76,049

ҮЙЛ ЯВДАЛ

ГАРААНЫ ӨМНӨХ АЖИЛЛАГАА АМЖИЛТАЙ ЯВАГДАЖ ДУУСАВ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээний гарааны өмнөх ажиллагаа өчигдөр амжилттай явагдаж өндөрлөлөө. Гарааны өмнөх ажиллагаагаар баг тамирчид жагсаалын үзүүлэх тоглолт, гар тулааны үзүүлэх тоглолт, нормативын бэлтгэлийг /биеийн тамир, гал, үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах/ гүйцэтгэсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн 2007 оноос хойш зохион байгуулагдаж байгаа бөгөөд 2008, 2009, 2011, 2013, 2015, 2017, 2019 онуудад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд явагдсан юм. Энэ жилийн тэмцээний онцлог нь Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлагуудын ротууд шинээр оролцож, эзлэгдсэн объектыг чөлөөлөх, гранат шидэх, буудлагын шинэ төхөөрөмжүүд ашиглах зэрэг өөрчлөлтүүдийг оруулсан. Өөрөөр хэлбэл, 1991 оноос хойш ротын бүрэлдэхүүн оролцдог нь тасалдаад байсныг энэ жилээс эргүүлэн сэргээсэн гэсэн үг юм.

Ротуудын тухай танилцуулахад Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн

командлалын ротын бүрэлдэхүүнд Зэвсэгт хүчний 014, 120, 123, 167, 186, 256, 327 дугаар ангидаас шалгарсан тамирчин дайчид багтаж байна. Тэдний 22 хувь нь цэрэгжлийн спортын цол, зэрэгтэй, 28 хувь нь Зэвсэгт хүчний аварга шалгаруулах Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Марш, тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээнүүдэд медальт байрт шалгарсан туршлагатай тамирчид юм. Тус ротын захирагчаар ахмад Г.Мөнхболд /123/ ажиллаж байна.

Харин Тусгай хүчний цэргийн командлалын ротын бүрэлдэхүүнд Зэвсэгт хүчний 084, 150, 330, 350 дугаар ангиудаас шалгарсан дайчид багтаж байна. Бүрэлдэхүүний 47 хувь нь цэрэгжлийн спортын цол, зэрэгтэй, 80 хувь нь Зэвсэгт хүчний аварга шалгаруулах Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээн болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээнүүдэд тэргүүн байруудад шалгарсан дайчид эзэлж байгаа юм. Тус ротын захирагчаар ахмад Б.Цээноров /350/ ажиллаж байна.

Баг тамирчдаас онцлох алба хаагчид бол эмэгтэй цэргийн алба хаагчдын тасаг юм. Орчин цагийн Зэвсэгт

хүчний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж байгаа энэхүү тэмцээнд хоёр эмэгтэй цэргийн алба хаагчдын тасаг оролцож байгаа нь ЗХЖШ болон Тусгай хүчний цэргийн командлалынх. Тухайлбал, Зэвсэгт хүчний Жанжин штабын эмэгтэй цэргийн алба хаагчийн тасгийнхны 80 хувь нь нийтийн болон цэрэгжлийн спортын цол, зэрэгтэй. Тасгийн захирагчаар ахмад Л.Саранзаяа /311/ ажиллаж байна.

Тэгвэл Тусгай хүчний цэргийн эмэгтэй цэргийн алба хаагчдын тасгийн бүрэлдэхүүн 100 хувь нийтийн болон цэрэгжлийн спортын цол, зэрэгтэй. Тасгийн захирагчаар ахмад Б.Хандсүрэн /330/ ажиллаж байна.

Энэ тэмцээний гол өнгө, өрсөлдөгчид мөн л хугацаат цэргийн алба хаагчид. Зэвсэгт хүчний 032, 119, 167 дугаар ангиудаас оролцож байгаа хугацаат цэргийн алба хаагчдын салааны бүрэлдэхүүнд шилдэг дайчид багтсан байна. Маргааш баг тамирчид тэсвэр хатуужил, авхаалж самбаа, мэргэжлийн ур чадвар, эр зориг, хурд хүчийг шалгасан тэмцээнээр үргэлжлүүлнэ.

Ташрамд, тэмцээнд оролцогч баг тамирчид цар тахлын халдвараас сэргийлэх хүрээнд вакцины хоёрдугаар тунгаа хийлгээд 20 гаруй хоносон алба хаагчид юм.

ТӨВ АЙМГИЙН ГЭР БҮЛ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАРТАЙ ХАМТРАН АЖИЛЛАВ



Тус нэгтгэлийн "Номын сангийн зөвлөл"-өөс номын өдрийг угтан "Хөл хориог хөгжил болгоё" 14 хоногийн аяны хүрээнд хугацаат цэргийн алба хаагч нарын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж Төв аймгийн гэр

Мөн 2021 оныг "Хүний хөгжил-Эрүүл мэндийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан "Бүх хайраа гэр бүлдээ" аяны хүрээнд Олон Улсын гэр бүлийн өдрийг угтаж Төв аймгийн гэр бүл хүүхэд, залуучдууны хөгжлийн газар, ИГБССНийгэмлэг, Төв



бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран ном хандивлах аян зохион байгуулав. Тус аянд Төв аймгийн аж ахуйн нэгж, байгууллага, төрийн алба хаагч нэгдэн оролцож нийт 273 ном ирүүлснийг тус газар нэгтгэлийн хугацаат цэргийн алба хааж буй залууст оюуны хөрөнгө оруулалт хийж хүлээлгэн өглөө.

аймгийн нэгдсэн эмнэлэг, Монголын Улаан Загалмайн нийгэмлэгүүдтэй хамтран ажиллаж "Халамжтай аав" нөлөөллийн арга хэмжээнд "Гэр бүл төлөвлөлт", "Халамжтай аав" зэрэг сэдвээр сургалтуудыг тус тус зохион байгууллаа.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

БАТЛАН ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМ БОЛГОНО

Нийслэлийн Цэргийн штаб 2021 оныг "Төрийн батлан хамгаалах үйлчилгээ-Цахим шинэчлэл"-ийн жил болгон зарласан. Зорилтын хүрээнд нийслэлийн Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Анхбаяраар ахлуулсан бүрэлдэхүүн Батлан хамгаалахын төв архив болон нийслэлийн дүүргүүдийн цэргийн штабын тоо бүртгэлийн офицеруудтай хурал зохион байгууллаа.

Тус хурлаар Батлан хамгаалах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд санал солилцсон юм.

Энэ тухай нийслэлийн Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Анхбаяр "Цар тахлын нөхцөл байдлаас улбаалж бид иргэдэд Батлан хамгаалах үйлчилгээг аюулгүй, түргэн шуурхай, дэвшилтэт технологид суурилсан байдлаар иргэдэд хүргэхээр цахим үйлчилгээний нэгдсэн портал "И-Монголиа"-тай хамтран ажиллаж байна. Тухайн иргэн өөрийнхөө хурууны хээ, эсвэл иргэний үнэмлэхээрээ төрийн үйлчилгээний ТҮЦ машинаас хаана, хэзээ, ямар ангид цэргийн алба хаасан, ямар хээрийн сургуульд оролцож байсан зэрэг олон төрлийн мэдээллээ

хуулбараар авах боломжтой үйлчилгээг нэвтрүүлэхээр зэхэж байна" гэсэн юм. Батлан хамгаалахын төв архивын дарга, хурандаа З.Эрдэнэбат "Манай байгууллага иргэдийн лавлагааны хүсэлтийг цахимаар хүлээн авч, хуулбарыг НДЕГ-ын шаардлагын дагуу үнэт цаасанд хуулбарлан, тамга, тэмдэгтэй нь гарган өгч үйлчилж байна. Цэргийн штабуудын үйл ажиллагаа Батлан хамгаалахын төв архивтай салшгүй уялдаа холбоотой. Иймд үйлчилгээгээ нэгтгээд цахим хэлбэрт шилжүүлэн иргэдэд үйлчлэхэд бид хамтран ажиллах болно" гэсэн юм.

100 ШИРХЭГ ШИНЭС МОДНЫ ТАРЬЦ СУУЛГАВ

Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлээд 11 жил болж байна. Энэ зарилгийн хүрээнд Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн байрлал болон БЗД-ийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Баянзүрхийн бага зүрхний ар энгэрт 2021 оны 5 дугаар сарын 15 өдөр Захирагчийн зэвсэглэл техникийн орлогч хошууч Б.Чимэддорж, орон сууцны дарга ахмад Б.Баянжаргал, ахлах ахлагч Ш.Есенкелд, ахлагч Б.Лхагвадорж нар шинэс мод тарих ажилд оролцож, 2021 оны 5 дугаар сарын 16 өдөр Батлан хамгаалахын сайдын өгсөн үүрэг даалгаврын дагуу ангийн байрлалд 100 ширхэг шинэс модны тарьц суулгах ажлыг ангийн эргүүл, жижүүр, харуул хоногийн манааны бүрэлдэхүүн ХЦАХ-тай хамтран хийж гүйцэтгэлээ.



Зэвсэгт хүчний 256 дугаар анги

Ангийн 2020-2021 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу хээрийн гаралт, полигоны дадлага, байлдааны буудлагатай ротын тактикийн хээрийн сургуулийг "Хүч нэмэгдүүлсэн танкийн рот давшилтад" сэдвээр амжилттай зохион байгууллаа. Салбарууд байлдааны буудлагатай хээрийн сургуулийн зорилго, зорилтыг биелүүлж танк, мотобуудлага, артиллер, миномёт, зенитийн

салбарууд амжилттай оролцлоо. Энэ удаагийн байлдааны буудлагатай хээрийн сургуулиар Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 113 дугаар тусгай салбарын ЗПУ-2 суурийн 2 тоотыг сурган дадлагуулж хамтран буудлага хийлээ. Мөн танкийн батальоны 44 хугацаат цэргийн алба хаагч бие дааж Т-55 танкаар буудлага хийсэн нь онцлог, ач холбогдолтой сургууль боллоо.

Хошууч Л.АМАРБАЯСГАЛАН

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна. Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

Дарга, ерөнхий редактор Хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ**

*Зар, рекламныг хямд нийтэлнэ.
*Зар, рекламны үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонинны нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонинны мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029